



**“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨХК-ИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Аудитын код: САГ-2018/69/СТА-ТӨҮГ**

**АУДИТЫН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын захирал бөгөөд, Тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг**  
Утас: 261885  
Цахимхаяг: [naranchimegts@audit.mn](mailto:naranchimegts@audit.mn)

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

**Аудитын менежер: Я.Самбууням**  
Утас: 260512  
Цахимхаяг: [sambuunyamy@audit.gov.mn](mailto:sambuunyamy@audit.gov.mn)

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан,  
зорилтот түвшний биелэлт

**ТАБ-ын хаяг: 3Г-ын IV байр**  
Бага тойруу 6, Улаанбаатар 46  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

**“Б энд С Аудит” ХХК-ийн  
Аудитын багийн ахлагч Д.Дашхорлоо**  
Утас:99099155

Улаанбаатар хот



Агуулга

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	3.
2. АУДИТЫН ТАЙЛАН	4
2.1 ОРШИЛ	4
2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	4
2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	5
2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН	5
2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	6
2.6 ДОТООД ХЯНАЛТ	6
2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	6
2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	6
2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	6
2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	6
2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР	7
2.11.1 Мөнгөн хөрөнгийн талаар	7
2.11.2 Дотоод хяналтын талаар	7
2.12 МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР	7
2.13 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ	7
2.14 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД	7
2.15 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	7
2.16 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	8
2.17 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	8
3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	10
3.1 Дотоод хяналтын талаар	11
3.2 НӨАТ-ын талаар	11
3.3 Өртөгийн талаар	12
3.4 ХХОАТ-ын талаар	13-16



## 1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН  
СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь, үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, орлого, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд өртөг зардал, Нэмэгдсэн өртгийн албан татвар болон хувь хүний орлогын албан татварын тооцооллыг татварт тайлагнах, эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн дансны бичилтийг залруулах шийдвэр гаргах зэргийг тусгаж зөвлөмж өгсөн болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно

### 2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээгээр “Б энд С Аудит” ХХК аудит хийлээ. САГ-2018/69/СТА-ТӨҮГ

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Эрчим хүчний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 01-ээс 2018 оны 03 дугаар сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн “Б энд С аудит” ХХК-ийн аудитын багийн ахлагч Д.Дашхорлоо, аудитор Д.Заяажаргал, Э.Дэлгэрцэцэг, аудиторовн туслах ажилтан Б.Эрдэнэтогтох нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайланг “Б энд С аудит” ХХК-д 2018 оны 02 дугаар 02-нд ирүүлсэн.



“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

“Б энд С аудит” ХХК нь аудитыг 2018 оны 02 дугаар сарын 02-оос 2018 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

### **2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК нь Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Эрчим хүчний тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, Зөрчлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Компанийн үндсэн зорилт нь хэрэглэгчийг дулаан, цахилгааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь цахилгаан үйлдвэрлэх, дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулахтай хангах, эрчим хүчний барилга байгууламж 35 МВт-ын, хүчин чадалтай өргөтгөл барих, зуухны засвар угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ зэрэг 7 тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь түлш тээврийн цех, зуухан цех, турбин цех, хими цех, цахилгаан цех, ДХХА цех, дулааны шугам сүлжээний цех, барилга механик цех гэсэн 8 цехтэйгээр үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд Эрдэнэт хотын Уулын баяжуулах үйлдвэрийн дулааны станцын хэрэглэгчдээс бусад үйлдвэр, албан байгууллагууд, орон сууцны хоороолуудыг дулаанаар хангаж, гаргасан цахилгаан эрчим хүчээ “Цахилгаан Дамжуулах Үндэсний сүлжээ” ТӨХК-ийн ХБС Эрдэнэтийн 220 кВ-ын дэд станцад нийлүүлдэг.

Тухайн байгууллагын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ҮР ДҮН**


Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 23-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцаж, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Интерактивын Даймонд програмаар боловсруулж, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллага гаргасан байна.



## 2.5 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зарлагыг сонгов.

Тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал 30,386.7 сая төгрөг бөгөөд материаллаг байдлын түвшинг түүний 2.0 хувиар тооцож 607.7 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд тооцсон суурь болон түвшинд өөрчлөлт ороогүй болно.

## 2.6 ДОТООД ХЯНАЛТ

Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт сул байна.

## 2.7 ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Эрдэнэтийн ДЦС” ТӨХК нь 2017 оны эдийн засгийн үндсэн зорилтот түвшингийн төлөвлөгөөнд орлого 34,222.4 сая, зардал 34,334.1 сая төгрөг байхаар төлөвлөж гүйцэтгэлээр орлого 34,372.1 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 149.7 сая төгрөг буюу 0.4 хувиар биелүүлж, зардалд 34,482.3 сая төгрөгийг зарцуулж 148.2 сая төгрөг буюу 0.4 хувиар хэтрүүлсэн, тайлант онд 49.4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 2.8 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2017 оны орлого, зардал болон Шилэн дансны тухай хуулиар тодорхойлсон бусад мэдээлэлүүдийг холбогдох баримтын хамт бүрэн байршуулсан байна.

## 2.9 ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 23 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдэлүүдээс өртөг зардал, бараа материал, цалин хөлс, үндсэн хөрөнгө, ногдол ашигтай холбоотой дараах зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг”, “хамааралтай байх”, “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдүүлийг хангахгүй байна.

## 2.10 ГОЛ, ОНЦЛОГ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, худалдан авалт, өр авлага, цалин хөлс, өртгийн зардал, ногдол ашиг, татвар тооцоолол зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгаж /ТАБ-СТА-В-3/ маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Эдгээр шалгасан нарийвчилсан горим, сорил нь тус байгууллагын нийт мөнгөн гүйлгээний 70%-ийг эзэлж байна.





“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

## **2.11 АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР**

Аудитын явцад аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **2.11.1 Дотоод хяналтын талаар**

Дотоод аудитор нь санхүү, эдийн засаг эрхэлсэн захирлын удирдлага дор хяналт, төлөвлөлт, борлуулалт, хэмнэлтийн хэлтсийн бүтцэд байгаа нь дотоод аудитын хараат бус ил тод, бие даасан байдал алдагдсан байна. Энэ нь компанийн тухай хуулийн 81.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ” заалттай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Дотоод аудитын бүтцийг оновчтой зохион байгуулж ажиллах зөвлөмж өгөх

### **МАТЕРИАЛЛАГ БУС ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР**

Аудитын явцад материаллаг бус хэмжээний санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн алдааг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.11 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад анхаарал татахуйц чухал асуудал гараагүй болно.

### **2.12 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД**

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Шарын гол” ХК-ийн нэрийн өмнөөс хувь хүний дансанд 400.0 сая төгрөг шилжүүлсэн, худалдах, худалдан авах гэрээ байгуулж “ДСТ” ХХК, “Броун айс” ХХК зэрэг компаниудаар ажил гүйцэтгүүлж гүйцэтгэлийн тооцоо хийгээгүй байгааг 2018 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

### **2.13 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

Тус байгууллагын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 195.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг зөвлөмж өглөө.


“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 195.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй 4 зөвлөмжийг Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.

### **2.14 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг “Ниямазон Аудит” ХХК гүйцэтгэж 5 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмж хэрэгжиж, 2 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Дотоод хяналт болон худалдан авалтын гэрээнд тусгагдсан НӨАТ-ийг тооцож аваагүй байна.

### **САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид “Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж дүгнэн “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт гаргалаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 15 хуудас, хавсралтууд 9 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ..... Д.ДАШХОРЛОО   Огноо:

**БЭЛТГЭСЭН:**

“Б ЭНД С АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР..... Д.ЗАЯАЖАРГАЛ   Огноо:

2018 оны 3 дугаар сарын 12







## “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Менежментийн захидал

#### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

##### Асуудал 1

Дотоод хяналт .....11

##### Асуудал 2

Татвар тооцоолол .....11

##### Асуудал 3

Өртөг ..... 12

##### Асуудал 4

ХХОАТ .....12

2018 оны 3 дугаар сарын 12



### **Менежментийн захидал**

Аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Иймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмж танай бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эрдэнэтийн ДЦС” ТӨХК-ийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Асуудал 1: Дотоод хяналт

Тэргүүлэх ач холбогдол №1

Ажиглалт

Дотоод аудитор нь санхүү, эдийн засаг эрхэлсэн захирлын удирдлага дор хяналт, төлөвлөлт, борлуулалт, хэмнэлтийн хэлтсийн бүтцэд байгаа нь дотоод аудитын хараат бус ил тод, бие даасан байдал алдагдсан байна. Энэ нь компанийн тухай хуулийн 81.2.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ” заалттай нийцээгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Зөвлөмж

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт, Компанийн тухай хууль, компанийн дүрэмд нийцүүлж, дотоод аудитын нэгжийн бүтцийг оновчтой зохион байгуулж ажиллах

2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор биелэлтийг ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудал 2: Татвар тооцоолол

Тэргүүлэх ач холбогдол №2

Ажиглалт

Худалдан авалтын гэрээнээс түүвэрлэн шалгахад гэрээнд НӨАТ-ын дүн орсон гэж тусгасан боловч 54.3 сая төгрөгт ногдох НӨАТ-ийн падаан аваагүйн улмаас 5.1 сая төгрөгийг хэмнэх боломжийг алджээ. Энэ нь НӨАТ-ийн тухай хуулийн 17.3.4."албан татвар суутган төлөгч хоорондын бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг баталгаажуулсан нэмэгдсэн өртгийн албан татварын падааны бүртгэлийг холбогдох мэдээллийн санд оруулж, мэдээллийг 7 хоногт багтаан нэгдсэн системд илгээнэ." заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Зөвлөмж

- НӨАТ-ийн тухай хуулийн 17.3.4-ийг мөрдөж ажиллах
- 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор биелэлтийг ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу



Асуудал 3: Өртөг

Тэргүүлэх ач холбогдол №3

Ажиглалт

Үйлдвэрлэлийн өртгийг тооцоходоо захиргаа удирдлагын зардалд хамааралтай НДШ, унаа хоолны хөнгөлөлт, элэгдэл, орон байрны хөнгөлөлт, сургалтын зардал, лицензийн төлбөр, албан томилолт, банкны шимтгэл, хэвийн ба хэвийн бус хорогдол, холбоо интернетийн төлбөр гэх мэт өртөгт орохгүй зардлуудыг оруулж тооцсон нь НББОУС-2, Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тогтоолын 6.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна байгууллагын НБББББ, дансны төлөвлөгөө, санхүүгийн програмтай нийцээгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Зөвлөмж

Холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллах

2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор биелэлтийг ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

○

Асуудал 4: ХХОАТ

Тэргүүлэх ач холбогдол №4

Ажиглалт

Хувь хүмүүсээс худалдан авсан бараа материал 190.7 сая төгрөгийг И-баримтад илгээсэн боловч ХХОАТ-ийн ТТ-12-т тайлагнаагүй байна. Энэ нь ХХОАТ-ийн тухай хуулийн 28.2.Энэ хуулийн 8.1.6, 11.1.6, 12.1.1, 12.1.2, 12.2, 13.1.1, 13.1.5, 14.1.2, 14.1.3, 15 дугаар зүйлд заасан орлогын албан татвар төлсөн тайланг хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлангийн хуудсаар гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ний өдрийн дотор татварын албанд хүргүүлнэ" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх.

Зөвлөмж

Холбогдох хууль, тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллах

2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор биелэлтийг ирүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

Хянасан:

Б энд С Аудит ХХК-ийн Захирал

Д.Дашхорлоо

Бэлтгэсэн:

Б энд С Аудит ХХК-ийн Аудитор

Д.Заяажаргал

2018 оны 3 дугаар сарын 12



**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2016	12/31/2017
Үдәүөдөөі өөөіә		
Ііәә аа оо, іі оуе ааөөдддд өөөіә	1,563,490,077.02	1,911,670,501.90
Ääííú ääëää	1,106,617,170.97	1,411,784,720.42
Татвар, НДШ-ийн авлага		35,460.00
Бусад авлага		
Ááðàà ààððääë	2,388,489,586.46	1,990,343,965.49
Óðüä÷ëëæ òëííí çàðààë/ òíííí	786,900,347.88	2,378,840,205.02
<b>Үдәүөдөөі өөөіә өөөі әлі</b>	<b>5,845,497,182.33</b>	<b>7,692,674,852.83</b>
Үдәүөдөөі аон өөөіә		
- íäñýí òòòíä	35,779,141,179.57	33,946,171,491.51
Биет бус хөрөнгө	7,137,327.76	6,276,692.65
Áóñàä òòòíä		
Óóðèìäèääñàí ýýyääyë		
Дуусаагүй барилга		
Óóðèìäèääñàí ýýyääyë		
Óäèäóóë ; ýýäyýíëë òòòíä		
<b>Үдәүөдөөі аон өөөіә өөөі әлі</b>	<b>35,786,278,507.33</b>	<b>33,952,448,184.16</b>
<b>Іеөд өөөіә</b>	<b>41,631,775,689.66</b>	<b>41,645,123,036.99</b>
Áíäëíí òóääòääò òò òòäá		
Ääííú ääëä	153,326,440.01	215,037,290.59
Цалингийн өглөг		
Татварын өр	22,658.80	61,951.78
НДШ-ийн өглөг		
ÍÄÒ-úí ääëä		
ÝíÄ-úí òèìäyëëé өглөг		
Óðüä÷ëëæ ìðíí ìðèíä	1,561,007,920.01	1,457,464,180.36
Бусад богино хугацаат өр төлбөр	26,508,315.91	47,092,765.70
<b>Áíäëíí òóääòääò òò òòäá</b>	<b>1,740,865,334.73</b>	<b>1,719,656,188.43</b>
Óðò òóääòääò òò òòäá		
Óðò òóääòääò çyýë		
Áóñàä óðò òóääòääò ääëä		
<b>Óðò òóääòääò òò òòäá</b>	<b>1,740,865,334.73</b>	<b>1,719,656,188.43</b>
<b>äò òòäá</b>	<b>1,740,865,334.73</b>	<b>1,719,656,188.43</b>
Ýçýìèä÷äëé òì÷	19,447,456,792.53	19,447,456,792.53
Төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
Óóäëéí		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	34,360,784,468.64	34,360,784,468.64
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг		
Óóðèìäèääñàí àðä	- 13,917,330,906.24	- 13,882,774,412.61
Òäèèäíäëé ; äëéí àðä		49,460,043.63
äííò ; äëéí àðä		- 13,932,234,456.24
<b>Ýçýìèä÷äëé òì÷äëéí äëí</b>	<b>39,890,910,354.93</b>	<b>39,925,466,848.56</b>
<b>Іеөд өөөіә аа үçýìèä÷äëé òì÷</b>	<b>41,631,775,689.66</b>	<b>41,645,123,036.99</b>



**АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/


ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2016	12/31/2017
<b>Борлуулалтын орлого /цэвэр орлого/</b>	<b>31,851,188,661.58</b>	<b>34,372,143,333.12</b>
<b>Áíðëóóëñàí áçóóúãäýõççíëë °ðò°ã</b>	<b>28,602,876,341.72</b>	<b>31,377,290,287.85</b>
<b>Íëëò àøëã</b>	<b>3,248,312,319.86</b>	<b>2,994,853,045.27</b>
Түрээсийн орлого		
Хүүний орлого	29,076,563.58	65,733,594.72
Бусад орлого	288,084,648.11	319,688,807.70
Борлуулалт маркетингийн зардал	(3,033,121,272.11)	- 2,823,499,610.46
Ерөнхий ба удирдлагын зардал	(264,596,836.63)	- 281,553,749.20
ÍAØ-ëéí çàðäãë		
Бусад зардал	(215,169,303.42)	- 219,188,684.92
Санхүүгийн зардал		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/ ~ íäñýí áóñ çéë àæëëëãããíú àøëã /àëããããë/		
Õçç òíðãóóëü ò°íã°ë°èðëéí àøëã /àëããããë/		
Гадаад вaëpòúí ðáíøëéí зөрүүний àøëã/алдагдал/		
Бусад ашиг алдагдал		
Олз гарзын дүн		
Áóñãã		
~ íäñýí áóñ çéë àæëëëãããíú àøëã /àëããããë/-úí äçí		
<b>Òàðããð ò°ë°òëéí °í°ò àøëã àëããããë</b>	<b>52,586,119.39</b>	<b>56,033,403.11</b>
Îðëíãúí ðàðããðúí çàðäãë	2,907,656.35	6,573,359.48
<b>Òàðããðúí äàðããð àøëã /àëããããë/</b>	<b>49,678,463.04</b>	<b>49,460,043.63</b>
Ííõãíé øéíæðýé ççéëñ-öýãýð		
<b>Òàëëãíò çãëéí öýãýð àøëã /àëããããë/</b>	<b>49,678,463.04</b>	<b>49,460,043.63</b>





**АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	/төгрөгөөр/	
<b>Үзүүлэлт</b>	<b>12/31/2016</b>	<b>12/31/2017</b>
Бариа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,649,313,906.98	30,582,602,405.19
Татаас санхүүжилтийн орлого		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	319,605,239.62	152,341,557.19
<b>Бариа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого</b>	<b>29,968,919,146.60</b>	<b>30,734,943,962.38</b>
Бариа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	6,562,826,932.16	6,373,282,780.14
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	1,905,682,937.65	1,874,869,954.70
Бариа материал худалдан авахад төлсөн	10,437,500,000.00	11,449,000,000.00
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	1,289,762,980.58	1,995,433,202.02
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	6,569,698,980.02	6,813,837,816.35
Татварын байгууллагад төлсөн	1,898,805,666.99	1,843,550,492.51
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	6,335,648.00	6,851,433.00
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	48,258,080.42	29,937,858.78
<b>Бариа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого</b>	<b>28,718,871,225.82</b>	<b>30,386,763,537.50</b>
<b>Бариа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого</b>	<b>1,250,047,920.78</b>	<b>348,180,424.88</b>
<i>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</i>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	-	-
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	-	-
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	-	-
<i>Мөнгөн орлогын дүн</i>		
Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	-	-
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Төлсөн ногдол ашиг		
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд		-
<b>Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд</b>	<b>1,250,047,920.78</b>	<b>348,180,424.88</b>
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	313,442,156.24	1,563,490,077.02
Аргаар өөрчлөгдсөн өөрчлөлтүүд	1,563,490,077.02	1,911,670,501.90




“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

**АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2015 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	19,447,456,792.5	34,341,739,238.0		-13,877,385,738.7	<b>39,911,810,291.9</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					<b>0.0</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	19,447,456,792.5	34,341,739,238.0	0.0	-13,877,385,738.7	<b>39,911,810,291.9</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					<b>0.0</b>
Өмчид гарсан өөрчлөлт					<b>0.0</b>
Зарласан ногдол ашиг					<b>0.0</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					<b>0.0</b>
<b>2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	19,447,456,792.5	34,360,784,468.6	0.0	-13,917,330,906.2	<b>39,890,910,354.9</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					<b>0.0</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	19,447,456,792.5	34,360,784,468.6	0.0	-13,917,330,906.2	<b>39,890,910,354.9</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				49,460,043.6	<b>49,460,043.6</b>
Өмчид гарсан өөрчлөлт					<b>0.0</b>
Зарласан ногдол ашиг				-14,903,550.0	<b>-14,903,550.6</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					<b>0.0</b>
<b>2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	19,447,456,792.5	34,360,784,468.6	0.0	-13,882,774,413.2	<b>39,925,466,848.6</b>



“Эрдэнэтийн Дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудит

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**